



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 26 өдөр

Дугаар A/486

Алтай хот

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/191 дүгээртэй Бугат сумын эмнэлгийн дотор ариун цэврийн байгууламж, душ хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны захирамжийн 1 дүгээр хэсэгт “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн” гэснийг “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн” гэж өөрчилсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг үнэлгээний хороо (С.Байгальмаа)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

